



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 20 өдөр

Дугаар Б/06

Ховд

Э.Дөлбадралыг ажилд эгүүлэн томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.2 дахь заалт, Ховд аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 21 дүгээр шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 551 дүгээр магадлал, Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүх хуралдааны 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 9 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шүүхийн шийдвэрийн дагуу Энхтөрийн Дөлбадралыг 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн Ховд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын албан тушаалд эгүүлэн томилсугай.

2. Э.Дөлбадралын ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталж, 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөрт багтаан ажил хүлээлцүүлэхийг ажлын хэсэг /Д.Энхболд/-т даалгасугай.

3. Э.Дөлбадралыг Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ"-ний ТЗ-10-3 дахь шатлал буюу 981742 төгрөг /есөн зуун наян нэгэн мянга долоон зуун дөчин хоёр/-өөр цалинжуулж, төрийн нууцын ажил эрхэлсний нэмэгдлийг үндсэн цалингийн 15 хувиар тооцон сар бүр олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын нягтлан бодогч /Г.Эсбаатар/-д зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Zax B/06 Ch
02 00516

Аймгийн Засаг даргын
2020 оны 02 дугаар сарын 20 –ны өдрийн
Б/06 дугаар захирамжийн хавсралт



ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЖИЛ ХҮЛЭЭЛЦЭХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Энхболд - Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд:

Н.Ганзориг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль,
эрх зүйн хэлтсийн дарга

Б.Ганболд - Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Г.Эсбаатар - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын нягтлан бодогч

Ч.Ганчимэг - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын нярав

-оОо-